



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, жуулчны
баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Жуулчны баазад тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Аянчин ХХК-ний "Аянчин" зочид буудлын 13/246, Мазаалай трейд ХХК-ний "Хавана" зочид буудлын 13/263, Мицо ХХК-ний "Лайф" зочид буудлын 14/92, Буянт их буурал ХХК-ний "Буянт" зочид буудлын 15/006, Алтан-Очир энд голд стар ХХК-ний "Очир" дэн буудлын 15/094, Тэнгис тэнгэр ХХК-ний "Тэнгис" дэн буудлын 14/78, Нямтөгс ХХК-ний "Гурвантөгс" дэн буудлын 15/004, Богд-Өөд ХХК-ний "Өлзий" Дэн буудлын 16/070, Иргэн Б.Энхтуяа "Эв" дэн буудлын 16/146, Сан жуулчин ХХК-ний "Сан" жуулчны баазын 16/152 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд

төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 01 сарын 24-
өдрийн 10 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.01.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Аянчин ХХК	2085437	Аянчин	БГД-ийн 19-р хороо Дамдинбазарын гудамж 55/3
2	Охьрио ХХК	5004772	Арк	БГД-ийн 1-р хороо 11-12 дунд
3	Мазаалай трейд ХХК	2024543	Хавана	БГД-ийн 2-р хороо ЭТӨЧ 43
4	Мицо ХХК	2808803	Лайф	БГД-ийн 6-р хороо ЭТӨЧ 67
5	Буянт их буурал ХХК	5434157	Буянт	БЗД-ийн 10-р хороо Улаанхуаран 1/11-191

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 01. сарын 21.
өдрийн А(03 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.01.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Алтан-Очир энд голд стар ХХК	5854806	Очир	БЗД-ийн 21-р хороо бага дарь эх 5 гудамж
2	Тэнгис тэнгэр ХХК	2885034	Тэнгис	БГД-ийн 1-р хороо замчдын гудамж 67/1
3	Нямтөгс ХХК	2615789	Гурвантөгс	БГД-ийн 22-р хороо 18-р гудамж 71 тоот
4	Богд-Өөд ХХК	5037212	Өлзий	БГД-ийн 15-р хороо Ард Аюушийн өргөн чөлөө
5	Иргэн Б.Энхтуяа	ЦД69112509	Эв	БЗД-ийн 10-р хороо ТЗ 66
6	Тэтун хангай ХХК	5493668	Тамир	БЗД-ийн 8-р хороо Улаанхуаран 10-252а
7	Бэх бат цайз ХХК	5392071	Анар	СБД-ийн 14-р хороо Хандгайтын 21-71

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 01. сарын 02-
өдрийн 09:03 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

ЖУУЛЧНЫ БААЗЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.01.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сан жуулчин ХХК	2627981	Сан	ЧД-ийн Их тойруу 47-р байр

--ооОоо--